3.7 Ашиглалтын цооногийн техникийн паспортыг хөтөлж Сумын ЗДТГ-т хүлээлгэж өгнө.

3.8. Инженерийн хийцтэй худгийг шинээр гаргасан далд ажлын тухай аймаг нийслэлийн ажлын хэсгийн акт №3 ийг үйлдэж эзэмшигчид хүлээлгэн өгнө.

3.9 Инженерийн хийцтэй худгийн усны шахуурга, шахуургын цахилгаан үүсгүүр, цахилгааны утас, хянах самбар, холбогч хэрэгсэл, дагалдах зүйлсийг иж бүрнээр худгийн цооногт суурилуулна. Худгийн усны шахуурга нь ISO9001 чанарын стандарт гарал үүслийн гэрчилгээтэй, үйлдвэрлэгчийн нэр, хаяг, бараны болон улсын гэрчилгээтэй үйлдвэрлэгчийн нэр, хаяг, барааны болон улсын гэрчилгээтэй байна.

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ БОЛОН ШААРДЛАГА

| № | ҮЗҮҮЛЭЛТҮҮД | |
|---|---|---|
| | 1. ЦООНОГ ӨРӨМДӨХ, ЦООНОГИЙГ ТОНОГЛОХ | |
| 1.1 | Геофизикийн судалгаа хийж, худгийн байршлыг эцэслэн тогтоох | |
| | Уст цэгийн гео цахилгаан зүсэлтийг хавсралтын дагуу бэлтгэх, усгүй буюу хэт бага устай гэж тодорхойлогдсон газар өрөмдөж илүү зардал гаргахгүй байхап анхаарах | |
| 1.2 | Цооногийн ашиглалтын ундарга нэг цэгт 2м3 /0.6л/-ээс /1.8л/с/ доошгүй байх | |
| 1.3 | Суултын яндангийн материал нь ган хоолой байна. | |
| 1.4 | Шүүрийн яндангийн материал нь ган хоолой байна. | |
| 1.5 | Ус өргөх яндангийн диаметр 18-20мм-ээс багагүй залгаасгүй байна. | |
| 1.6 | Ус шүүх хайрга нь шигшсэн мөлгөр хэлбэртэй, тоосонцор хольцгүй, мөхлөгийн хэмжээ 9мм-ээс томгүй байна. | |
| 1.7 | Тунгаагуурын гүн 2м-ээс багагүй. | |
| 1.8 | Худгийг шавхалт хийж цэвэрлэх хугацаа 24 цагаас багагүй | |
| 1.9 | Усны чанарын сорилт авах шинжилгээ хийлгэх | |
| 1.10 | Худгийг түр хугацааны тагаар тоноглох | |
| 1.11 | Мал услах онгоцонд ус өгөх хоолой нь 60мм диаметртэй, гаднах ханаас 2м урттай, гадагшилсан ган хоолойг цонхны доор гаргах | |
| 1.12 | Ундны ус авах хоолой нь 60мм диаметртэй ган хоолойг цонхны доор гаргах ундны ус авахад тохиромжтой байдлаар уртыг сонгох | |
| | 2. ХУДГИЙН НАСОС, ГЕНЕРАТОР, ЦАХИЛГААНЫ УТАС, ХЯНАХ САМБАР | |
| 2.1 | Гүний насос ISO9001 стандартын шаардлага хангасан монгол орны уур амьсгалын нөхцөлд ашиглах боломжтой байх | |
| 2.2 | Цахилгааны утас 3-4 салаа ус чийгний хамгаалалттай, худагт ашиглах шаардлагыг хангасан насос-с хянах самбар хүртэл үргэлжилсэн /залгаасгүй/ ус өргөх янданд 2м тутамд хавчиж /туузаар ороож болохгүй/ тогтооно. | |
| 2.3 | Хянах самбар асаах унтраах товчлууртай насос ашиглаж буйг /ногоон/ хүчдэл буйг /улаан/ гэрлээр асаах индикатортой насос ажиллуулах асаагууртай | |
| 2.4 | Бага оврын генератор: бинзенээр ажилладаг ISO стандартын шаардлага хангасан монгол орны уур амьгалын нөхцөлд ашиглах | |
| | 3. ХУДГИЙН БАРИЛГА | |

Инженерийн хийцтэй гүн өрмийн худгийн

техникийн тодорхойлолт

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Захиалагч: Говь-Алтай аймгийн Халиун сумын ЗДТГ
1.2. Шаардагдах хөрөнгө:
1.3. Санхүүжилт: 70,000.000.
1.4. Худгийн тоо: 2.
1.5. Худаг гаргах газар: Лүүн. Бат. Оконбулаг газарт.

Хоёр. АЖЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

2.1.Худгийн өрөмдлөгийн болон барилгын явцын үеийн болон дараах үеийн гэрэл зургийг авч, худгийн солбилцлыг тодорхойлсон байх.

2.2 Худгийн цооног өрөмдөх, тоног төхөөрөмж суурилуулах ажилд тавих техникийн шаардлага MNS6088:2010 стандартын дагуу өрөмдлөг, шавхалт, туршилтын ажлыг явуулах, худгын усны шахуурга, цахилгаан үүсгүүрийг сонгох худгийн барилга барих ажлыг гүйцэтгэх.

2.3 Худаг шинээр гаргахад худгийн барилга дотор усан сан байгуулах, халаалтын зуух, мал услах онгоц, талбайг тендерт оролцогч хариуцаж гүйцэтгэнэ.

3. Монгол улсын ХХАА-н сайд, БО-ны сайд, Сангийн сайдын 2015 оны 7 дугаар марын 15 өдрийн 101, 189, 194 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан инженерийн хийцтэй худаг уст цэгийн сэргээн засварлах, шинээр гаргах, санхүүжүүлэх, эзэмших, ашиглах нийтлэг журмыг мөрдөнө. Үүнд:

3.1 Ажлын иж бүрдэлд цооног өрөмдөх, цооногийг цэвэрлэх, гавхарт туршилтын ажил хийх, ус шахуурга, цахилгаан үүсгүүр суурилуулах, худгийн барилга усаг сан мал умлах онгоц, талбай зэргийг барьж байгуулах ажлыг багтаана. Өрөмдмөл худгийн барилга дотор 1.5м куб-ээс дээш багтаамжтай усан сан барьж байгуулна.

3.2 Инженерийн хийцтэй худаг шинээр гаргах тухай аймаг нийслэлийн ажлын хэсгийн акт№1- ийн дагуу ажлын төрөл хэмжээ өртгийг тогтооно.

3.3 Инженерийн хийцтэй худаг шинээр гаргаж хүлээлгэн өгсөн тухай аймаг нийслэлийн ажлын хэмгийг акт №2 -ыг үйлдэж сумын комисст хүлээлгэн өгч, орон нутгийн өмчид тусгуулна.

3.4 Худаг гаргахда өрөмдөхийн өмнө хайгуулын ажлаар устай эсэхийг тогтоосон акт үйлдэнэ.

3.5 Худгийн цооног өрөмдлөгийн ажлын талаар мэдээллийг өрөмдлөгийн ажлын журналд тэмдэглэнэ.

3.6 Өрөмдлөгийн ажлыг дууссаны дараа шавхалтын ажлыг заавал хийж шавхалтын ажлын журналыг дэлгэрэнгүй үйлдэнэ.

1дэх өдөр захирамж гаргах
- Тендер зарлах.

| | | |
|---|---|---|
| 3.1 | Худгийн барилгын дотор багтаамж нь 18м3-аас багагүй дотор талдаа усан сан халаах зуух, цооногоос усан сан, усан сангаас мал услах онгоцруу ус дамжуулах хоолой, ус дамжуулах хоолойтой барилга нь гадна талдаа хаяавчтай, төмрөөр дээврлэсэн байна. | |
| 3.2 | Худгийн моторын яндан заавал худгийн барилгаас гадагш гаргах эсвэл, цонхтой байх, худгийн хаалгыг салхируу харуулах, худагд 40x40см хэмжээтэй цонх гаргана. | |
| 3.3 | Мал усдах онгоц нь 9м-ээс багагүй урттай 400мм-ийн голчтой, хагас цилиндр, ган яндан буюу цутгамал төмөр бетоноор хийж мал услах онгоцны 2 талд 0.5м өргөнтэй цементэн хавтангаар талбайг бат бөх суурилуулна. | |
| | 4. ХУДГИЙН АЖЛЫГ ДУУСГАЖ ХҮЛЭЭЛГЭЖ ӨГӨХ | |
| 4.1 | Худгийн техникийн паспортыг хөтөлж сумын Засаг даргын Тамгын газарт хүлээлгэн өгөх | |
| 4.2 | Худаг гүний насос жижиг оврын генераторыг ажиллуулах, үйлчилгээ хийх, талбайн сургалт хийх | |
| 4.3 | Талбайг цэвэрлэх, өрөмдлөгийн шлам, барилгын болон ахуйн хог хаягдал | |

ХАЛИУН СУМЫН ЗДТГ-ЫН ОНХС-ИЙН 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨТ АЖИЛ БОЛОХ ИНЖЕНЕРИЙН ХИЙЦТЭЙ ГҮН ӨРМИЙН ХУДАГ ГАРГАХ АЖЛЫН ДААЛГАВАР

Халиун сумын нутаг дэвсгэрт нийт ..... ширхэг худаг гаргах барилга байгууламжийг нь барьж гэрээний хугацаанд хүлээлгэж өгнө.

1. ......... газар тариалангийн зориулалттай нэг худаг техникийн тодорхойлолтод заагдсан шаардлагын дагуу бөгөөд худаг гадна талдаа онгоц халаалтын зуухны шаардлагагүй. Худгийн гадна талдаа 5тн ус нөөцлөх савыг байршуулж ус нь бүрэн шавхагдахаар байрлуулж холбох шланкыг дагалдуулан өгнө.
2. ....... ундны усны зориулалттай нэг худаг техникийн тодорхойлолтод заагдсан шаардлагын дагуу бөгөөд худаг гадна талдаа онгоц халаалтын зуухны шаардлагагүй. Худгийн дотор ус нөөцлөх 1-1.5 тн ус нөөцлөх савыг байршуулна.
3. .......... багт хүн малын ундны усны зориулалттай ... худгийг техникийн тодорхойлолтод заагдсан шаардлагын дагуу иж бүрэн хийж гүйцэтгэнэ.